

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдал (2014 оны жилийн эцсийн байдлаар)

I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2014 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 69.6 хувьтай буюу 4486.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 135.9 хувиар давж биелэн 1736.0 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 6222.2 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 80.5 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 40384.4 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 89.5 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 8094.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 20412.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр 7390.1 сая төгрөг, нийт 35898.2 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Дэлгэрцогт, Дэрэн Говь-Угтаал, Баянжаргалан, , Өндөршил, Хулд, Гурвансайхан, Сайнцагаан Эрдэнэдалай, Адаацаг сумд 0,4-122,6 хувиар давуулан биелүүлсэн байна. Харин Луус, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумд 0,1-44,7 хувиар буюу

58,0-182839,5 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө тасласан байна.

II. Төсвийн зарлага



2014 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 39608,0 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22,0 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 16751,5 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10,2 хувиар өсөж нийт зардлын 42 хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын зардал 9236,1 сая төгрөгт хүрч нийт зардлын 23 хувийг эзэлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ 3247,7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 15,9 хувиар буурч нийт зардлын 8 хувийг эзэлж байна. Төсөвт байгууллагын өглөгийн үлдэгдэл 448,0 сая төгрөг болж өмнөх оноос 4 дахин өссөн бол, төсөвт байгууллагын авлагын үлдэгдэл 193,3 сая төг болж 14 хувиар өссөн байна.

III. Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 27,6 хувиар өсч 71636,0 сая төгрөг болов. Үүнээс хугацаа хэтэрсэн зээл 130,5 сая төгрөг болж өссөн бол чанаргүй зээл 93,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс 25,0 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 0,31 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оноос 14,1 хувиар өсч 25919,1 сая төгрөг болов.

IV. Хүн ам нийгмийн үзүүлэлтүүд




Хүн ам: Суурин хүн амын ХА-3 мэдээгээр 2014 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн ам 44207 болж өмнөх оноос 193 хүнээр буюу 0,43 хувиар буурсан байна. Цагаандэлгэр ,Говь-

Угтаал, Хулд , Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн сумдын хүн ам өмнөх оноос 0,1-2,4 хувиар өсч бусад сумдын хүн ам 0,4-3,7 хувиар буурсан байна. Нийт хүн амын 21906 нь буюу 49,6 хувийг эмэгтэйчүүд 50,4 хувийг эрчүүд эзэлж байна. Нийт хүн амын 12403 нь буюу 28,0 хувийг 0-14 насныхан, 28475 буюу 64,4 хувь нь 15-59 насныхан, 59 дээш насныхан 3329 буюу нийт хүн амын 7,6 хувийг эзэлж байна. 100 болон түүнээс дээш настай 5 хүн байгаагийн 3 нь эмэгтэй байна. Өрхийн тоо 13448 болж өмнөх оноос 166 –аар буюу 1,2 хувиар өссөн байна. Өрхийн тоо өссөнөөр нэг өрхөд ногдох хүн амын тоо буурч 3,4 болсон байна.



Хүн амын ердийн хөдөлгөөний ХА-1 мэдээгээр 2014 онд 1031 хүүхэд шинээр мэндэлж өмнөх оноос 2 хүүхдээр буюу 0,2 хувиар буурсан байна. Шинээр мэндэлсэн хүүхдийн 551 нь эрэгтэй 480 нь эмэгтэй хүүхэд байна. Амаржсан эхчүүдийн 676 нь буюу 65,6 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой, 25,5 хувь нь суурь боловсролтой үлдсэн 8,9 хувь нь бага болон боловсролгүй байна. Мөн нийт амарсан эхчүүдийн 51,0 буюу 526 нь батлуулсан гэр бүлтэй, 338 буюу 32,8 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 167 нь гэр бүлгүй эмэгтэйчүүд байна.



2014 оны байдлаар нийт 180 гэр бүл шинээр бүртгэгдсэний 72,5 хувь нь 18-24 насны залуучууд байна. Тухайн онд 39 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос буурсан байна. Үүний 25 нь 4-9 жил хамт амьдарсан гэр бүл, 12 нь 15-с дээш жил, 2 нь 1-3 жил гэр бүл байсан байна.

Өнгөрсөн оны байдлаар 270 хүн нас барсан бөгөөд өмнөх оноос 4,9 хувиар буурсан байна. Нийт нас баралтын 67,8 хувийг эрэгтэйчүүд 32,2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна..

Тухайн онд 30 хүүхэд бусдад үрчлэгдсэний 12 нь эмэгтэй 18 нь эрэгтэй хүүхэд байна. Насны бүлгээр авч үзвэл нийт хүүхдүүдийн 23 нь 0-3 настай, 3 нь 3-6 насны, 4 нь 7-с дээш насны хүүхэд байна

Хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээгээр 2014 онд манай аймагт 669 хүн шилжин ирсэний 204 нь 0-14 насны хүүхэд, шилжин ирэгсэдийн 344 нь эмэгтэйчүүд байна. Тус аймагт шилжин ирэгсэдийн 297 нь буюу 44,4 хувь нь Улаанбаатараас, 93 нь Өмнөговь аймгаас, 85 нь төв аймгаас, 72 нь Говьсүмбэрээс, 32 нь Дорноговь аймгаас шилжин ирсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Нийт 1450 хүн ам шилжин явсан бөгөөд өмнөх оноос 11,0 хувиар буурсан байна. Нийт шилжин явагсадын 51,5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол 25,5 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байна. Шилжин явж байгаа иргэдийн 998 нь буюу 68,8 хувь нь Улаанбаатар хотруу, 358 нь буюу 24,7 хувь нь Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Төв аймгууд руу шилжсэн байна. Үлдсэн 65,5 хувь нь бусад аймаг руу шилжжээ.

2014 оны жилийн эцсийн байдлаар тус аймгийн хувьд 37 бүтэн өнчин хүүхэд, 437 хагас өнчин хүүхэд бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12,4 хувиар буурсан байна. Нийт өнчин хүүхдүүдийн 6,5 хувийг 0-4 насны хүүхэд, 21,3 хувийг 5-9 насныхан, 31,8 хувийг 10-14 насныхан, үлдсэн 40,4 хувийг 15-с дээш насны хүүхдүүд эзэлж байна.

18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүний тоо 1242 болж өмнөх оны мөн үеэс 23,6 хувиар өссөн бол эдгээрийн 85,5 хувь нь эмэгтэйчүүд 15,5 хувь нь эрэгтэйчүүд байна. Нийт өрх толгойлсон хүмүүсийн 818 нь 1-3 хүүхэдтэй, 334 нь 3-5 хүүхэдтэй, 90 нь 6 болон түүнээс дээш хүүхэдтэй байна. Аймгийн хэмжээнд ихэр хүүхэдтэй өрх 97 байгаа бол, 96 нь 2 ихэр хүүхэдтэй, 1 нь 3 ихэр хүүхэдтэй өрх байна. Ганцаар биеэр амьдарч байгаа ахмад настаны тоо 827 байгаа бол эдгээрийн 570 нь 55-с дээш насны эмэгтэйчүүд 257 нь 60-с дээш насны

эрэгтэйчүүд байна. Тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настан хүний тоо аймгийн хэмжээнд 24 байгаа бол 15 нь эмэгтэй 9 нь эрэгтэй хүн байна.


Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 1982 болж өмнөх оны мөн үеэс 2,3 хувиар өссөн байна. Эдгээрийн 826 нь бувуу 41,7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл 39,6 хувь нь төрөлхийн 60,4 хувь ердийн өвчин, ахуйн осол, зам тээвэр, үйлдвэрийн осол зэргээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон байна. Нийт тахир дутуу иргэдийн 183 нь 0-14 насны хүүхэд байгаа бөгөөд тэдгээрийн 87 нь эмэгтэй хүүхэд байна.

V. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд энэ онд төрөлт нэмэгдсэн ба нийт төрсөн эхчүүдийн 86,3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

Нялхсын эндэгдлийн тохиолдол 16 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос нэмэгдсэн бөгөөд 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 16,9 ногдож байна. Харин 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан ба Өндөршил суманд 1 хүүхэд өвчний улмаас эмнэлэгт, Баянжаргалан, Дэлгэрцогт суманд тус бүр 1 хүүхэд гэрээр энджээ.




Эрүүл мэндийн газрын мэдээгээр нас баралт өнгөрсөн оноос нэмэгджээ. Нас барсан хүний 13,4 хувь буюу 31 хүн эмнэлэгт нас барсан байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 30,2 хувийг эзэлж байна. Мөн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдол 20 гарч, нийт нас баралтын 8,6 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бүтцээр нь авч үзвэл амиа хорлосон 5, бусдад хорлогдсон 1, зам тээврийн осол 10, бусад осол 4 байна.

2014 оны байдлаар стационарит шинээр 10971 эмчлүүлэгч хэвтэж 10879 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 81827 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,5 байна.

Энэ оны байдлаар 170364 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 33,7%, амбулаторийн үзлэг 47,6 %, идэвхитэй хяналт 13,2 %, гэрийн үзлэг 5,6 %- ийг эзэлж байна.

2014 оны байдлаар хорт хавдрын 88 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсээс 70 хүн нас барсан байна.

Аймгийн хэмжээнд энэ оны байдлаар халдварт өвчний 340 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 23 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 76,6 болж өмнөх оны мөн үеэс буурсан байна.



Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл халдварт шар өвчин 1,8 хувь, Бэлгийн замын халдвар 54,1 хувь, Амьсгалын замын халдвар 29,1 хувь, сүрьеэ 7,9 хувь, гэдэсний халдвар 3,2 хувь, бусад өвчлөл 3,8 хувийг тус тус эзэлж байна.


VI. Нийгмийн даатгал




Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны жилийн эцэст 21178,5 сая төгрөг,

зарлага 21595,0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 3754,8 сая төгрөг буюу 21,5 хувь, зарлага 4234,5 сая төгрөг буюу 24,4 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого, жил бүрийн эцсийн байдлаар, /сая төгрөг/



Аймгийн нийгмийн даатгалын сангийн зарлага, жил бүрийн эцсийн байдлаар, /сая төгрөг/



Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд энэ 2014 онд 10423 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2379 хүн буюу 22,8 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4100 хүн буюу 39,3 хувь нь төсөвт байгууллагаас, 3944 хүн буюу 37,9 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэл төлөгчид 15,4 хувиар сайн дурын шимтгэл төлөгчид 3,8 хувиар, төсөвт байгууллагын шимтгэл төлөгчид 0,8 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2014 онд 17096,2 сая төг болж, үүний 79,4 хувийг өндөр настны, 14,7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.1 хувийг тэжээгчээ алдсаны, 2.9 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ 2014 онд тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6299 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 77,9 хувь буюу 4909 хүн өндөр насны, 16,7 хувь буюу 1053 хүн тахир дутуугийн, 3,7 хувь буюу 232 хүн тэжээгчээ алдсаны, 1.7 хувь буюу 105 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Мөн энэ 2014 онд тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2007 ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 35, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагчид 145 хүн байна.

Энэ онд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 33655 байгаагийн 75,1 хувь буюу 25286 төр хариуцах иргэд, 16,9 хувь буюу 5696 малчид, 8,0 хувь буюу 2673 оюутан суралцагсад, аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.


2014 оны эцсийн байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 8082,9 сая төгрөг болж төлөвлөгөө нь 18,8 хувиар тасарсан үзүүлэлттэй байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Сайнцагаан сумаас бусад сумд бүгд тасалсан байна.

VII. Боловсрол



2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 7.6 мянга байгаа нь өнгөрсөн оноос 0.6 хувиар өссөн байна.

ЕБС-д суралцагсад



2013-2014 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийг 823, 11-р ангийг 479 хүүхэд төгссөн нь өмнөх хичээлийн жилээс 11-р ангийг төгсөгчид 101 хүүхдээр буурч харин 9-р анги төгсөгчид 17 хүүхдээр өссөн байна. 2014-2015 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 906 хүүхэд элссэн нь өмнөх хичээлийн жилээс 9.8 хувиар өссөн байна.

Дотуур байранд суудаг хүүхдийн тоо энэ хичээлийн жилд өмнөх оноос буурч 805 хүүхэд болов.

VIII. Хөдөө аж ахуй




2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2435.7 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 439.5 мянган толгой буюу 22.0 хувиар өсч, тэмээ 28.0 мянга, адуу 105.1 мянга, үхэр 46.0 мянга, хонь 1114.8 мянга, ямаа 1141.8 мянган толгой болж, таван төрөл дээрээ өссөн байна.

малын тоо /мян.толгой/



Аймгийн нийт сумдын 86.7 хувь буюу 13 сум 100.0 мянгаас дээш толгой малтай байгаагийн дотор Эрдэнэдалай сум хамгийн олон буюу 368.1 мянган мал тоолуулсан бол хамгийн цөөхөн мал тоолуулсан Цагаандэлгэр сум 93.1 мянган толгой мал тоолуулав.




Аймгийн хэмжээнд нийт 5880 малчин өрхийн 11214 малчид байгаагаас 46.4 хувь буюу 5203 нь эмэгтэйчүүд байна. Нийт малчдын 15-35 насны малчин 3786 буюу 33.8 хувь, 35-59 насны малчин 6114 буюу 54.5 хувь, 60-аас дээш насны малчид 1314 буюу 11.7 хувийг тус тус эзэлж байна.

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 417 болж, өмнөх оноос 56.2 хувиар өссөн байна. Үүний дотор хоёр мянгаас дээш малтай малчин 27 байгаагийн гадна Эрдэнэдалай, Гурвансайхан, Говь-Угтаал, Сайнцагаан сумд мянгат малчны тоогоор тэргүүлж байна. Аймгийн хэмжээгээр оны эхний төллөвөл зохих эх малаас 816.2 мянган төл, үүнээс ботго 5551, унага 23860, тугал 14442, хурга 396.8 мянга, ишиг 374.0 мянган толгойг бойжуулсан байна.

Оны эхний эх малын 96.2 хувь нь төллөж, гарсан төлийн 99.8 хувь нь бойжсон байна. Энэ онд оны эхний малын 0.1 хувь буюу 1822 том мал хорогдов. Үүний дотор

оны эхний тэмээний 0.1 хувь, адууны 0.1 хувь, үхрийн 0.3 хувь, хонины 0.1 хувь, ямааны 0.1 хувь нь хорогджээ.



2014 онд аймгийн дүнгээр 142,1 тонн төмс, 39,3 тонн хүнсний ногоо хураан авав. Өнгөрсөн онтой харьцуулахад хураан авсан төмс 18,7 тонн буюу 15,2 хувиар, хүнсний ногоо 7,5 тонн буюу 23,4 хувиар тус тус өссөн байна. Мөн аймгийн хэмжээгээр 9307,2 тонн гар тэжээл бэлтгэсэн нь өмнөх оноос өсчээ.

IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2014 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний үнийн индекс 2013 оны жилийн эцэстэй харьцуулахад 11.2 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 2014 оны жилийн эцэст 2013 оны жилийн эцсээс 11.2 хувь өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.9 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг 6.7 хувь, хувцас бөс, бараа гутлын бүлэг 12.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 2.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 17.8 хувь, тээврийн бүлэг 5.8 хувь, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 4.8 хувь, боловсролын бүлэг 11.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур, байрны үйлчилгээний бүлэг 13.0 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ, 12сард, 7 хоногоор


№	Барааны нэр, төрөл	XII/3	XII/10	XII/17	XII/24	XII/31
1	Гурил, I зэрэг, кг	1150	1150	1150	1150	1150
2	Хонины мах, кг	6000	6000	6000	6000	6000
3	Үхрийн мах, кг	0	0	0	0	0
4	Ямааны ястай мах	5500	5500	5500	5500	5500
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1600
6	Цагаан будаа, кг	2200	2200	2200	2200	2200
7	Шингэн сүү, л	1900	1900	1900	1900	1900
8	Ноолуурын үнэ 1кг: - Цагаан	58000	58000	58000	58000	58000
	- Бор	58000	58000	58000	58000	58000
	- Холимог	58000	58000	58000	58000	58000
9	Бензин, А-80, 1 л	1570	1570	1570	1570	1570
10	Бензин, А-92, 1 л	1810	1810	1810	1810	1810
11	Дизелийн түлш, 1 л	1890	1890	1890	1890	1890

Х. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2014 оны жилийн эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 260 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар өсч 229 хүн холбогдоод байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар хүн амь, дээрэм, булаалтын гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бусдын өмчийн хулгай 23.6 хувиар буурсаны дотор иргэдийн өмчийн хулгай 39.5 хувиар буурсан, харин малын хулгай 10.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 32.7 хувийг бусдын бие махбодьд гэмтэл учруулсан, 35.4 хувийг хулгайн, 12.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.1 хувийг хүчин, 4.6 хувийг танхайрах хэрэг тус тус эзэлж байна.



Нийт гэмт хэргийн 33.07 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 88 хүн байхад Дэлгэрцогт 171, Дэрэн 123, Цагаандэлгэр 120, Баянжаргалан 132, Гурвансайхан 102, Сайнцагаан 129 хүн байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 590.8 сая төгрөг, түүний 53.8 хувь буюу 317.9 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна.

XI. Бүртгэлтэй ажилгүй иргэн



2014 оны 12 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа 512 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 274 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 52.3 хувь буюу 268 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 172 ажилгүйчүүд ногдож байхад Өндөршил /594/, Говь-Угтаал /428/, Дэрэн /309/, Эрдэнэдалай /239/ байгаа нь аймгийн дундачаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 14.3 хувь нь дипломын болон баклавын дээд, 3.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.3

хувь нь техникийн болон мэргэжлийн, 33.8 хувь нь бүрэн дунд, 27.3 хувь нь суурь, 11.3 хувь нь бага, 3.9 хувь нь боловсролгүй иргэд байна.

Ажлын байрны зуучлал

Хөдөлмөрийн хэлтсийн 2014 оны жилийн эцсийн мэдээгээр 860 хүн ажлын байранд зуучлагдан орсон байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 38.1 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 30.1 хувь нь ХАА ан агнуур ойн аж ахуй, 6.4 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 5.2 хувь нь зочид буудал, зоогийн газар, 4.9 хувь нь бөөний ба жижиглэн худалдаа, 15.3 хувь нь бусад салбарт ногдож байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих сан:

2014 онд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилготой жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангуудаар дамжуулан иргэд аж ахуй нэгж нийт 1987.9 сая төгрөгийн зээл олгож 529 ажлын байр хадгалагдан үлдэж 1196 ажлын байрыг шинээр бий болгосон үр дүнтэй ажилласан байна.

XII. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2014 оны байдлаар 6349.9 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45.6 хувь буюу 1989.1 сая төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 48.8 хувийг уул уурхайн олборлох аж үйлдвэр, 19.9 хувийг боловсруулах аж үйлдвэр, 31.3 хувийг цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус тус эзэлж байна.

XIII. Барилга.



Аймгийн дүнгээр энэ онд 23650,6 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 2248,0 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн нь өмнөх

оноос 2.4 дахин өсөв.

нэ онд 7142,3 сая төгрөгийн орон сууцны барилга, 768,4 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалтай барилга, 376,0 сая төгрөгийн эрүүл мэндийн салбарын барилга, 5711,1 сая төгрөгийн боловсрол соёл, спортын салбарын барилга, 1117,1 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 929,9 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 4328,5 сая төгрөгийн эрчим хүчний салбарын барилга, 2057,6 сая төгрөгийн инженерийн шугам сүлжээний барилга угсралт, 1219,7 сая төгрөгийн бусад зам талбайн ажил хийгдсэн байна.



XIV. Дундговь аймгийн нутгаар 2015 оны 1 р сард цаг агаар ямар байх тухай урьдчилсан төлөв

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус хүйтэн байх бөгөөд олон жилийн дунджаас 1.0-1.5 градусаар дулаан байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 17-22, өдөртөө 7-12 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 14-19, өдөртөө 0-5 градус хүйтэн байна. Харин нэгдүгээр арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч нийт нутгаар шөнөдөө 27-32, өдөртөө 16-21 градус хүйтэн байна. Бусад хугацаанд нийт нутгаар шөнөдөө 22-27, өдөртөө 11-16 градус хүйтэн байна.

Энэ сард нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас ахиу, нутгийн зүүн өмнөд хэсгээр олон жилийн

дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй.

Салхи нэг ба гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үе, эцэс, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 12-14 м/с, хүрч ширүүсэх төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Нэгдүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджаас дулаан, хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу орох төлөвтэй байна. Одоогийн байдлаар нийт нутгаар цасан бүрхүүл тогтоогүй байна. Нэгдүгээр сард цас орсноор цасан бүрхүүл тогтож, улмаар цасны зузаан нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлж болзошгүй байна. Мөн түүнчлэн сарын эхэнд үе үе хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаанд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

2015 оны 2 дугаар сарын ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 12-17 градус хүйтэн буюу нийт нутгаар дунджийн орчим байна. Энэ сард нутгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.